

САНААЛАГ ЗҮЙЛИЙН МӨН ЧАНАРЫН ТУХАЙ

Ж Отгонбаяр МУБИС.тэнхмийн эрхлэгч

Түлхүүр үгс: субъект, объект, үйл ажиллагаа, субъект-объектон харилцаа, операция, субстрат, функци, виртуаль чанар, соёлын тэмдэг.

Өмнөх үг Санаалаг хэмээх энэ өвөрмөц ертөнц сонгодог философи үүссэн тэр цагаас эхлэн түүний үндсэн, тулгуур судлагдахуун болж ирсэн билээ. Чухамхүү санаалаг ертөнцийн язгуур мөн чанарын тухай асуудлыг хэрхэн авч үзэж, яаж шийдвэрлэснээрээ философичид аливаа урсгал чиглэл, өвөрмөц дэг сургууль, лагерьт хуваагдан онол номлолоо хөгжүүлсэн түүхтэй. Манай оронд философийн боловсролыг үлэмж хэмжээгээр үзэл сурталжуулан түгээж байсан цаг дор «ангич», «намч» материалист философийн сүүдэрт нь хоцорсон судлагдхуун бол санаалаг зүйлийн тухай асуудал байлаа. Хэрвээ энэ асуудлыг гүнзгийрүүлэн судалж зохих байранд нь тавихыг оролдвоос идеалист дайсан хэмээх нэр зүүж амьдын тамд унах байсан биз ээ.

Гэтэл хүн төрөлхтний оюун сэтгэлгээний идэвхтэй, хөгжлийн ирээдүйг илүүтэйгээр бэлгэдсэн үзлийг тээж ирсэн хүмүүс бол мөнөөх идеалист сэтгэгчид байсан нь маргашгүй үнэн билээ. Яагаад гэвэл, тэд мөн л хөгжил хөдөлгөөн, хүний эрх, эрх чөлөө, чөлөөт сэтгэлгээ, оюуны эрхэмсэг оршихуйг дээдлэгчид байсан юм.

Санаалаг зүйл хүний дотоод эрхэмсэг оршихуй, үнэлэмжийн ертөнцөд тал бүрээр нөлөөлөн эзэмдэх тул хүн судлалтай холбоотой олон салбар ухаан, феноменологи, психологи, мөн эстетик, урлаг, соёл судлал, шашин, шашны философид ямагт судлагдахуун болж байдаг. Түүнчлэн санаалаг зүйлийн тухай ойлголт нь ертөнцийг үзэх философи үзлийн бүрдэлд онцгой байр эзэлдэг. Гэхдээ би энэ байр суурь, чиг үүргийнх нь тухай биш, харин уг ойлголтын илэрхийлж буй бодот харилцаа, ерөнхий философи утгын тухай хөндөж ярих гэсэн юм.

Санаалаг зүйлийн утга учрыг философийн үндэстэй ойлгоно гэдэг нь, үндсэндээ, сэтгэн бодохуйн уг чанар, зүй тогтлыг илрүүлж, улмаар танин мэдэхүйн үйл явцын тухай философи онолыг тодотгон нарийвчлах, уг процессыг зорилго чиглэл, ухамсартайгаар залж жолоодон төлөвшүүлэх гэсэнтэй агаар нэгэн буй.

Монгол оронд чөлөөт сэтгэлгээ үнэт зүйл болон төлөвшиж эхэлсэн цагаас манай философичид ажил мэргэжлээ үзэл суртлын хүлээснээс чөлөөлсөн нь гавьяат үйл мөн билээ. Манай нийгэм нэлээд философижиж байна. Хэн хүнгүй л нэлээд философидох болжээ. Хэлсэн, ярьснаа ч «философи» хэмээн тодотгох нь олонтаа болжээ. Болохгүй нь юу байхав, энд гайхах зүйл алга аа. Харин мэргэжлийн хүмүүс мэргэжлийн ойлголт, категорийг мэргэжлийн салбарт мэргэжлийн бус байдлаар хэрэглэвээс, энэ нь л гайхмаар бөгөөд чухамдаа эмгэнэлтэй.

Энд өгүүлж буй санаалаг зүйл хэмээх философи ойлголт нь англи хэлэн дээр «Idea», герман хэлэн дээр «Ideale», «Idee», орос хэлэн дээр «идеальное», «идеальность», «идеальный образ» гэх зэрэг нэр томъёонуудаар илэрхийлэгддэг. Харин манайд уг ойлголтын философи

утгыг илэрхийлэхийн тулд мэргэжлийн ном зохиолд санааны зүйл [Философийн толь, УБ., 1990. орчуулга], санаалаг зүйл, санаалаг ахуй [Философи. Сурах бичиг. УБ., 2002], санаалаг ертөнц гэх зэрэг нэр томъёог хэрэглэсэн байдаг.

Үгэн илэрхийлэл, ойлголтон утга хоёрыг, эсвэл философи хэлийг ердийн хэлтэй хольж хутгасан баримт бол, нэгдүгээрт, ухамсар, сэтгэл гэсэн ойлголтуудыг санаалаг зүйлтэй адил мэт үзэж байгаагаас гадна, түүнийг тэдгээрээс төрмөл, үүсмэл мэтээр үздэг явдал, хоёрдугаарт, хувь хүний субъектив ертөнцийг санаалаг зүйлтэй адилтгадаг байдал, гуравдугаарт, санаалаг зүйлийг бурхан, сүнс гэх мэт ид шид, далдын хүчтэй адилтгадаг явдал, дөрөвдүгээрт, санаалаг зүйлийг гариг орчлон, эрхэс тэнгэрийн сүр хүч, байгалийн аливаа үзэгдэл, юмсын зохистой бүтэц, эерэг энергийн нөлөөлөлтэй адилтган төсөөлдөг «натуралист» хандлага мэргэжлийн ном зохиолд орон зай эзэлсээр байгаа явдал юм.

Санаалаг зүйл хэмээх ойлголтыг нэр томъёоны талаас нь авч үзвээс, санаа маягийн, санаархуу, өөрөөр хэлбэл, санаатай төсөөтэй боловч санаа биш зүйл гэсэн үг юм. Санаануудаас бүрдсэн санааны зүйл биш юм!

Санаалаг зүйлийн тухай философи үзэл баримтлалууд Санаалаг зүйлийн мөн чанарын тухай авч үзэхэд философийн төвшинд тулгардаг асуудлууд нь, а/ санаалаг зүйл ба ухамсрын хамаарлын тухай, б/ түүний экзистенциалтай холбоотой орон зай, байршлын тухай, в/ мөн түүнийг зөөж «тээвэрлэж», агуулж байдаг материаллаг тээгч буюу субстратын тухай зэрэг юм.

Орчин цагийн философид эдгээр асуудлын хувьд байдал ямар байна вэ гэсэн асуултанд хариулахын тулд эл тухайд зонхилогч гурван үзэл баримтлал байгаагийн гол утгыг товч дурдъя.

1. "Нейродинамикийн" хэмээн тодотгодог нэлээд уламжлалт шинжтэй үзэл ёсоор бол, санаалаг зүйл нь чухамхүү хувь индивидын субъектив ертөнцийн хүрээнд байдаг өвөрмөц содон үзэгдэл бөгөөд түүнийг тээгч субстрат нь юуны өмнө хүний тархи юм [1:]. Энд санаалаг зүйлийг субъектив бодот байдалтай, тухайлбал, ухамсар дахь дүрүүдийн нийлбэр цогцтой адилтгадаг ба санаалаг зүйлийг объектив бодот байдлын бүх хэлбэрт, түүний дотор объект-хэлний материаллаг тэмдгүүдийн хэлбэрт ч сөрөг утгатай гэж үздэг. «Санаалаг зүйл бол бие хүний хувьд идэвхижсэн мэдээлэл юм, энэ бол мэдээллийг цэврээр нь байлгах ба түүгээр үйлдэл хийх бие хүний чадвар юм... Санаалаг зүйл бол тархины тодорхой (одоохондоо маш муу судлагдсан) хэв маягийн нейродинамикийн процессоор дамжин хэрэгждэг үлэмж индивидуаль шинжтэй үзэгдэл юм» [2: 187, 189].

2. Санаалаг зүйл бол объектив бодот байдлын онцгой төрөл мөн болох тухай «үйл ажиллагааны» хэмээх тодотголтой нэгэн сонирхолтой үзэл баримтлал байдаг. Энэ үзэл ёсоор, санаалаг зүйл гэдэг нь субъектын дотоодод, тархиных нь нейродинамикийн өөрчлөлтүүдээс үүсдэг бясалгал, санаашрал огт биш, харин хүний үйл ажиллагаа ба соёлын ямар нэгэн зүйл дэх юмс хийгээд үзэгдлийн анги, олонлогийг хамаарах ерөнхий шинжийн орлон төлөөлөл буюу репрезентаци юм. [3: 173]. Э.В.Ильенков санаалаг зүйл бол нийгэм-соёлын онцгой зүйл-репрезентант болох тухай ойлголтдоо санаалаг зүйл бол хүний материаллаг үйл ажиллагааны өвөрмөц бүтэц (хэлбэр) болох тухай тодорхойлолтыг нэмэлт болгосон байдаг. Санаалаг

зүйл бол хүний биет, бодот үйл ажиллагаа өөрөө биш, харин түүний схем (дүр) бөгөөд толгой, тархины гадна орших хэлбэртэй зөвшилцөн байдаг аж. Тиймээс санаалаг зүйл нь ухамсраас үүсдэг бус, харин түүнийг үүсгэдэг анхдагч шинжтэй. Ухамсраас үл хамаардаг учраас санаалаг зүйл нь түүний хувьд уул хад, ой мод, Нар, Сар, одтой тэнгэр шиг объектив бүрдэл зүйл болой. Ухамсар, хүсэл зориг бол санаалаг зүйлийг үүсгэгч шалтгаан биш, харин гагцхүү түүний үр дагавар, түүний илрэх психик хэлбэрүүд л ажээ. Энэ үзлийг английн философич Д.Бэкхерст тусгайлан судалсан байдаг [4:] Эдгээр эрс тэс байр суурьтай үзлийг нэгтгэх гэсэн оролдлого нэг бус удаа гарч байсныг тэмдэглэх нь зүйтэй.

3. Ширүүн маргаан дагуулсан дээрх асуудлын шийдвэрийг авч үзсэн «эталон онол» хэмээн тодотгогддог бас нэгэн хувилбар санал 1980-аад оны дундуур бий болсон юм. Түүнийг үндэслэгч нь Михаил Лифшиц билээ (4:). Түүний үзэл нь санаалаг зүйлийн орон зайг байгаль тийш улам дэлгэрүүлсэн аж. Тэрээр байгальд өөрт нь, тэр тусмаа биологийн амьтан болохынх нь хувьд хүнд санаалаг зүйл байхгүй хэмээн үзсэн Э.В.Ильенковийг эрс шүүмжлээд, «хэрвээ санаалаг зүйл нь хүний үйл ажиллагааны хэлбэр юм бол уг хэлбэр байгалийн гадна биш, харин байгальд л байж таарна. Хэрвээ хүний хөдөлмөрийн ажиллагаа нь байгалийн үйл явцыг даган дууриасан ашигтай үйл байгаагүйсэн бол хаанаас ямар нэг санаалаг зүйлийг гаргаж ирэхсэн билээ?» (4: 123). Байгалийн болон нийгмийн юмс, үйл явцын төгсгөлөг шинж, төгс төгөлдөр байдалд зарим объектив хязгаарууд байдаг. Эдгээр хязгаарууд нь бодтой хэмжээ, үлгэр жишиг, загвар эталон бөгөөд объектив бодот байдалд хамаардаг, тэдгээрийг ухамсар эсвэл хүсэл зориг дур зоргоороо өөрчилж чадахгүй.

Нийгэм-түүхийн практикийн тусламжтайгаар байгалиас салсан хүн өөрт нь илүү ойр, дөхүү түлхүү, төгөлдөржсөн эдгээр хязгаарыг илрүүлж, ойлголтын хэлбэрүүддээ, объектив ертөнцийн субъектив дүрүүдэд тусгадаг. Идеал хий, идеал талст гэх зэрэг нь мөн тийм төгөлдөржсөн бодтой хийсвэрлэлүүд байх бөгөөд тэдгээрт ойртож дөхөж болно. Олон өнцөгтийн талуудын тоог хязгааргүй өсгөх тусам дугуй дүрс рүү ойртож, дөхөж очдогийн нэгэн адил. Ийнхүү Лифшиц санаалаг зүйл гэж объектив-бодот загварууд, эталон жишгүүд, аль нэгэн оногдохууны хүрээний төгс боловсронгуй төлөөлөгчдийг нэрлэн, оршихуйн хязгаарыг нь «өргөтгөж» зөвхөн хүний толгойд, зөвхөн нийгмийн үйл ажиллагаанд төдийгүй, байгальд ч, нийгмийн үйл явцад ч, бие хүний амьдралд ч оноож байна. Философи сэтгэлгээний түүхэнд асуудал хэрхэн өрнөв?

Эрт цагаас янагш санаалаг зүйлийн тухай философичдын маргаан, мэтгэлцээн унтарч тасалдах нь байтугай, улам нарийсан гүнзгийрч, хүн төрөлхтний сэтгэн бодохуйг тэтгэн хөгжүүлж түүхийн өртөөг дамжин бидний эринд хүрч ирсэн ажээ. Хамгийн анх түрүү энэхүү ойлголтыг эртний Грекийн сонгодог философид Платон хэрэглэсэн байх бөгөөд тухайн цаг үед тэрээр хэлбэр дүр, гадаад байдал, төрөл, дүрс, арга, эв дүй, барил гэсэн үгэн (ойлголтон бус!) утгатай байжээ. Платоны хувьд санаалаг зүйл нь хүний ухамсраас дээгүүр, байгалиас дээгүүр, объективчлогдсон хэлбэр байлаа. Яагаад гэвэл, түүний үзэж буйгаар, хүний амьдрал үйл ажиллагааг байгалийн хууль биш, харин төрийн хууль шууд удирддаг. Үүгээр хүний оршихуй амьтныхаас ялгаатай. Тэрээр төгс төгөлдөр төрийн тухай үзэлдээ төрийн тухай төсөөллөө зөвхөн эрх зүйн эсвэл улс төрийн бүтцээр

хязгаарлаагүй, харин тухайн хувь хүний авир үйлдэл, түүний хүсэл зориг ба ухамсрыг, мөн хэлний грамматик хэм хэмжээнүүд, ур дарх хийгээд урлагийн дүрэм журам, шашны зан үйл гэх мэтийг шууд тодорхойлдог соёлын ерөнхий хэлбэрүүдийн бүх системийг ойлгож байлаа. Тиймээс хүн бол, түүний авч үзэж байгаагаар, нэгж биет биш юм, харин төрөөс үүсгэн буй болгосон бие хүн, буюу соёлын ерөнхий хэм хэмжээнүүдийг өөриймшүүлж, баримтлан дагагч хүн юм. Өөрөөр хэлбэл, энд хүн хэмээх эрхэмсэг оршихуйг бүтээгч язгуур ерөнхий харилцааг онцолж байна.

Бид санаалаг зүйлийн философи агуулгыг хөгжүүлсэн Платоны (Платон – Фихте – Гегель) чиглэлийнхний ач гавьяаг сайхнаар дурсахдаа Демокритын (Демокрит – Спиноза – Дидро – Фейербах чиглэлийнхэн) боловсруулсан эйдотик онолыг анзааралгүй өнгөрвөөс алдас болох буюу (5: 333). Демокритын үзэж буйгаар, биет микроскопон дүр болох эйдос нь *нэгдүгээрт*, бүхэллэг зүйлийн гол шинжүүдийг өөртөө нягтруулснаар бүхэллэг объектын хэсэг болж байдаг (одосгийн шинжлэх ухааны хэлээр яриваас, фракталь шинжтэй мэт!), *хоёрдугаарт*, объектоос салж бие даасан шинжийг олсноор субъектэд харьцах харилцаанд уг объектыг орлон төлөөлсөн репрезентант нь болдог, *гурвдугаарт*, объектоос субъект руу мэдээллийг зөөх төдийгүй, өөрөө хүний ухамсрын бүрдэл элемент нь болдог.

Танин мэдэхүйн үйл явц ба түүний үндэс, сурвалжийн тухай энэхүү эйдотик онолын санаа хожмын философичдын зохиол бүтээлд янз бүрийн байдлаар тусгагдаж, судлагдсан байдаг. Үүний жишээ нь, Локк, Дидро нарын сенсуалист үзэл, рационалист хязгаарын Спинозагийн сэтгэдэг биетийн тухай пантеист концепци болон сэтгэн бодохуйг чухамхүү хүний тархины биет онцлогоос “ялгаруулах” гэсэн «вульгари» хязгаарын Бюхнер, Фогт, Молешотт нарын үзэл юм.

Философи үзлүүдийн нэгдэл буюу синтетик хандлага. Ийнхүү эрт, эдүгээгийн философи үзлүүдийг харьцуулан харахад тэдгээрийн дотоод логикт нь ижил төсөөтэй зүйл байгааг харгалзан зарим тэмдэглэгээг хийж, дүгнэлт гаргаж болох мэт санагдана. Ингэхдээ “үйл ажиллагааны” хэмээх хандлагыг нэгтгэгч суурь болгож болох юм. Өөрөөр хэлбэл, асуудлыг *субъект-объектон нэгдмэл харилцаанд* тулгуурлан авч үзэх нь зүйтэй. Энэ харилцаа нь *гурван гишүүнтэй*. Энэ байр сууринаас авч үзэхэд, нейродинамикийн онол нь санаалаг зүйлийн мөн чанарыг дээрх харилцааны *субъектын* талд эрж хайсан байхад гурав дахь концепци буюу эталон онол түүнийг *объектын* талд, харин хоёр дахь концепци энэ хоёр туйлын завсар дахь гуравдагч гишүүн болох *үйл ажиллагааны* хүрээнд уг мөн чанарыг тайлбарлах оролдлого хийжээ. Тухайлбал,

1. **СУБЪЕКТ** - Үйл ажиллагаа - Объект

2. Субъект - **ҮЙЛ АЖИЛЛАГАА** – Объект

3. Субъект - Үйл ажиллагаа - **ОБЪЕКТ**

Эндээс харахад энэхүү гурван концепци нь нэгэн нэгдмэл бүхэллэг харилцааны гишүүн тус бүрийн хүрээнд тусгаар тусгаар байдлаар эрэл хайгуулаа хийсэн байна. Иймд эдгээр оролдлогуудыг нэгтгэн дүгнэж, философийн хувьд товчоолохуйц материал хэдийнээ бэлэн болжээ гэж үзэж

байна. Ерөнхий логикийг нь ажиглахад «санаалаг зүйл» хэмээх ойлголтын хүрээ, багтаамжийг өргөтгөх чиглэлээр эдгээр эрэл хайгуул хийгдсэн байна. Субъектын ухамсар, түүний үйл ажиллагааны бүтэц ба практик үйлдлийн хүрээнд татагдан орж буй объектуудын шинж чанар хооронд бодотой төсөө байгаа юм. Хүний сэтгэхүй нь бодот байдлын ерөнхий шинжүүдийг зуучуудаар дамжуулан тусгадаг. Эдгээр зууч бол хөдөлмөрийн зүйл хийгээд багаж зэвсгийг орлон төлөөлөгчид, өөрөөр хэлбэл, хэлний тэмдэгтүүд юм. Дашрамд хэлэхэд, санаалаг зүйл ба хэлний тэмдэг, тэмдгийн референт, тэмдгэн системийн уялдаа хамаарлын талаар энэхүү өгүүлэлийн хүрээнд дэлгэрэнгүй авч үзэх бололцоо үгүй билээ.

Энэ бүх эргэцүүллийг онолын үндэс болгон санаалаг зүйл бол өөрмөц содон үзэгдэл бөгөөд энэ утгаараа бүхэллэг шинжтэй субъект-объект харилцааны функц мөн гэж тодорхойлж байна. Энд субъект, объект нь практикийнх байна уу, эсвэл тэдгээрээс үүсмэл танин мэдэхүйнх байна уу ялгаагүй юм. Яагаад гэвэл, материаллаг болон оюуны үйл ажиллагаа нь нэгэн нэгдмэл процесс бөгөөд цагираган бүтэцтэй аж [6: 98]. Энд функц гэсэн ойлголтыг уялдаа холбоо бүхий систем тус бүр дэх өөрчлөлтүүд нь нөгөө систем дэх өөрчлөлтүүдийг хамаарч, дагалдах харилцаа юм гэсэн ерөнхий философийн утгаар хэрэглэж байна.

Нэгэнт санаалаг зүйлийг субъект-объект харилцааны функц гэж үзэж байгаа болохоор түүний оршихуй биет статустай байж болохгүй нь ойлгомжтой. Эс тэгвэл түүний функциональ шинж нь утгаа алдах юм. Гэхдээ энэ шинжийг субъект, объектын биелэг, эрчимлэг, мэдээлэллэг үйл явцыг өөртөө багтаагч харилцан үйлчлэлтэй нь адилтгаж болохгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Санаалаг зүйл нь ухамсартай адил биш боловч төрөлсөж болох тул түүний язгуур шинжийг биет субъектээс объектын махбодтой харилцан үйлчлэх үйлийн энергетик үзүүлэлтүүдтэй шууд холбож үзэж ч болохгүй юм.

Тийм учраас санаалаг зүйл бол гагцхүү субъект, объектын харилцан үйлчлэлд л байдаг мэдээлэл оршихуйн онцгой арга юм [7: 54] гэсэн санааг зөвшөөрч хүлээн авахаас өөрцгүй. Хийсвэр-логик сэтгэлгээний түүхэн хөгжилтэй уялдуулан авч үзвээс энэхүү харилцан үйлчлэлийн (хүний үйл ажиллагааны) оногдхууны ба операциональ гэсэн хоёр талыг соёл-түүхийн тэмдгүүд орлох болсон аж (биет, практик сэтгэхүйгээс хийсвэр-логик сэтгэхүй рүү шилжсэн шилжилтийг гайхамшигтай судалсан олон бүтээлүүд байдгийн нэгийг дурдахад, Выготский Л.С Избранные психологические исследования. М., 1956). Ийнхүү жинхэнэ биет-эталон зүйлстэй биш, харин тэдгээрийн орлогчидтой нь ажиллах бололцоотой болсон болохоор бодот байдал субъектын хувьд хоёр хэсэгт хуваагдаж байна, өөрөөр хэлбэл, гадаад юмсын ертөнц ба тэдгээрийн орлогч болох тэмдгүүдийн ертөнц бий болдог..

Энэ бүхнээс дүгнэхэд, санаалаг зүйл нь биет юмс биш, харин үйл явц юм, тодруулбал, юмсыг биш, тэдгээрийн гол шинжүүдийг хуулбарлан бүтээдэг репрезентацийн үйл явц юм. Нийгмийн орон зайд биет юмыг шинжүүд болон харилцаануудаас нь ялгана гэдэг маш бэрх. Хэдий тийм ч гэлээ, бид биет юм эсвэл түүний шинжийг дан дангаар нь биш, харин салшгүй бүрэн бүтэн байдлаар ажиглаж харж байдаг гэж үзвэл зохилтой. Биет юмны оршихуйн чухал шинж тэмдэг бол орон зай, цаг хугацаалаг

байршил билээ. Тийм ч учраас Р.Декарт биет шинжийг орон зай эзлэх шинжтэй адилтгаж байсан нь санамсаргүй хэрэг биш ажээ.

Ердийн координат бүхий ямар нэгэн тодорхой биетийг (уураг тархи, хувь индивид, хүний «нийгмийн бие» гэх мэт) санаалаг зүйлийг шууд тээгч субстрат гэж үзэж болохгүй, яагаад гэвэл тэрээр субъект-объектон харилцааны функци болох тухай дээр өгүүлсэн билээ. Харин тийм субстрат нь нийгмийн хүрээ болон физик орон зайд байнгын хөдөлгөөнд орших онцгой шинж байж болох юм. Энэ бол нийгмийн материйн шинж! Өөрөөр хэлбэл, санаалаг зүйлийн субстрат нь объектоой ажиллах субъектын операци (оюуны операци руу шилжиж байгаа практик операци) буюу системлэг чанар байдлаар субъект, объектын хоорондын харилцаанд илэрч байгаа шинж юм. Энэ нь биет чанарын орших арга биш болохоор физик орон зайн тухайн эгшинд баригдашгүй урсан өнгөрөх үйл явцлаг чанар юм. Уг үйл явцлаг байдал нь зөвхөн шинж болон харилцааны төдийгүй, мөн биетийн төлөвийг тодорхойлдог. Ийм урсан өнгөрөх үйл явцлаг байдал ба системлэг чанарыг нэгэн зэрэг илтгэсэн нэр томъёо шинжлэх ухааны эргэлтэнд хэдийнээ бий болжээ. Энэ бол «виртуаль шинж» хэмээх нэр томъёо юм.

Тэгэхээр санаалаг зүйл өөрөө болоод түүний субстрат нь виртуаль шинжтэй болж таарч байна. Өөрөөр хэлбэл, санаалаг зүйл нь виртуаль оршихуйн нэгэн төрөл юм. Виртуаль хэмээх латин гарлын үг нь болзошгүй, болох, эсвэл болох ёстой гэсэн утгатай аж. Завсрын гэмээр төлөв байдалд байдаг, зарчмын хувьд үл ажиглагдах эгэл хэсгүүд байж болохыг квант физикийн онол зөвшөөрдөг билээ. Одоо ч тэр, ирээдүйд ч тэр тэдгээрийг ямар ч багаж хэрэгслээр илрүүлж бүртгэх бололцоогүй байдаг аж. Энэхүү нэр томъёог хэрэглэхийн сацуу санаалаг зүйл нь орон зайлаг чанартай, энэ чанар нь биет байдлын орон зайлаг чанараас эрс өөр гэдгийг дахин тэмдэглэх байна. Энэ бол өвөрмөц орон зай!

Санаалаг зүйл нь онцлог бүхий гуравдагч орон зайлаг чанар, улмаар биет шинж үүсгэлгүйгээр, субъект, объектын орон зайнд мөнхүү оршин байдгаас тийм өвөрмөц обьектив байдал болдог. Тийм ч учраас түүний субстрат нь биет юм (биет болох субъект ба объект) биш, харин субъект, объектын харилцан үйлчлэл, контакт болох үйл ажиллагаа юм. Энэхүү субстрат нь «цэвэр» үйл ажиллагаа буюу түүний хэлбэр нь юм. Энэ хэлбэр бол операци. Операцийг үйлдэлтэй андуурах явдал цөөнгүй гардаг. Бид аливаа үйлдлийг гүйцэтгэхэд хоёр асуулттай тулгардаг. Энэ нь юу хийх вэ?, яаж хийх вэ? Эхнийх нь зорилготой холбоотой, хоёр дахь нь түүнийг хэрэгжүүлэх нөхцөлтэй холбоотой [8:].

Операци бол багаж хэрэгсэл, тэмдгийн системээр дамжуулан үйлдлийг хэрэгжүүлж, зорилгыг хангах арга юм. Чухамхүү санаалаг зүйлийн тухай рефлексийг хийгээд үйлдлийн арга болох энэхүү операциональ шинж философи сэтгэлгээний тулгын чулууг тавилцсан гэж үзэх үндэслэл бий. Операци өөрөө санаалаг зүйл биш, харин түүний субстрат нь юм. Тийм ч учраас "технэ" мэдлэгийн тухай эргэцүүлж, "софи" хэмээх үгийг сайтар "сонсож чагнах" аваас дархчуулын хотхоны алх дөшний чимээ сонсдох нь гарцаагүй үнэн билээ. Хожим соёлын үзэгдлийг тэмдэглэн дэлгэрсэн Софи нь эртний грекийн ертөнц, түүний домог, туульс зэрэгт урлан бүтээгч хүнийг ч, урлах хийгээд дархлах чадварыг нь ч, мөнхүү урласан дархалсан бүтээлийг нь ч хамтатгагч нэр байсан аж. Чухам л "Дархан хүн бурхан

ухаантай" хэмээх санааг илтгэж байжээ. Тэгэхдээ энэ бол өөр ярианы сэдэв юм.

Философи арга зүй ба практик хэрэглээ. Одоо санаалаг зүйлийн тухай философи онол тодорхой шинжлэх ухаанд арга болж, тухайлбал, хүн төлөвшлийн үйл явцтай, түүний дотор сургалтын үйл ажиллагаатай хэрхэн холбогдож хэрэглэгдсэн тухай өгүүлье. Дээр өгөгдсөн тайлбараас харахад, санаалаг зүйл бол угаасаа хувь хүнээс дээгүүр, нийгмийн шинжтэй, бүр цаашилбал хүн төрөлхтний үнэт зүйлс, эрхэмнэл юм. Харин хувь хүн тэдгээрийг өөриймшүүлэн "өмчилснөөр" соёлыг бүтээгч субъект болж, "олон" соёлын орчинд идээшин хөрвөх чадвараа дээшлүүлж байдаг. Тийм ч учраас санаалаг зүйл бол Субъект, Объектын хооронд репрезентантаар дамжсан харилцаа мөн болохыг интериоризацийн тухай психологи онол хүмүүнлигийн ухаан талаас нь нотолж, тодорхой арга зүй болгосон билээ. Хүүхдийн танин мэдэх үйл явцыг ухамсар зорилготойгоор жолоодон хөгжүүлэхэд интериоризацийн онолын онц ач холбогдлын тухай ярих нь илүүц биз ээ. Энэ онолыг хэрэглэсэн практик үйлдлүүд ч санаалаг зүйлийн субстрат нь операци мөн болохыг нотолсон гэж үзэж байна.

Энд, мэдээж хэрэг, оюун ухааны төлөвшлийн тухай Жан Пиажегийн /1896-1980/ генетик-психологи үзлийг онцлон дурдъях ёстой. Түүний үзэл баримтлал, психологи онол нь Америкийн Нобелийн шагналт физикч, философич Перси Уильямс Бриджмены /1882-1961/ философийн нөлөөн дор үүсэж төлөвшсөн гэдгийг ч тэмдэглэе. Логикийн буюу сэтгэн бодох үйл ажиллагааны зүй тогтлуудын угтал дүрийг субьектын гадаад үйл ажиллагааны бүтцээс эрэх ёстой гэж үзсэн Пиажегийн төлөвлөгөө, зорилго туршилтаар батлагдан тодорхой үр дүнгээ өгч, гадаад үйлдэл нь дотоод буюу оюуны үйлдэл = сэтгэхүй болон хувирах процесс олон түвшинтэй, нарийн төвөгтэй гэдгийг илрүүлжээ.

Энэ үйл явц сенсомоторын /хөдөлгөөний/ түвшингээс эхэлж, хэд хэдэн үе шатыг дамждаг. Эхний үе шатуудад хөдөлгөөн эмх цэгцгүй, харилцан уялдаагүй байдаг. /Хүүхэд анх тоглоомоо аваад ажигладаг, "судалдаг", бусад юмстай харьцуулдаг, мөн тоглох үйл дээр нь томчуултай үг хэлээр харьцах үйл, үйлдэл нэмэгддэг/. Энэ үе шатуудад хүүхдийн тоглох үйлдэл, хөдөлгөөнүүд нь операциуд биш юм. Учир нь тоглоом нь үгэн тэмдэгтээ /орлон төлөөлөгчөө/ олоогүй, юмсын /биетүүдийн/ тусгал нь репрезентантай холбоогүй байдаг. /Өөрөөр хэлбэл, энэ үед хүүхдэд уг чанартаа санаалаг зүйл байхгүй байна гэсэн үг!/.

Харин дараачийн, харьцангуй дээд үе шатуудад хүүхдийн хөдөлгөөн нь эмхэрч цэгцрэхээс гадна харилцан хамааралтай, харилцан орлогдох шинжтэй болдог. Нэгэн ижил төрлийн юмст хандахдаа адил хөдөлгөөн "хэрэглэгддэг" /аягыг зөв бариулж гарыг нь зөв хөдөлгөөнд сургахаас эхлээд бүхий л үйлдэл асрагчийн хараа хяналт дор хийгддэг/. Өөрөөр хэлбэл, ижил хөдөлгөөнүүд олон дахин давтагддаг. Эдгээр хөдөлгөөнд үйлдлийн их, бага ямар нэгэн тогтвортой схем обьектив байдалтайгаар үүсдэг. Энэхүү схем нь ижил төрлийн юмсын ерөнхий шинжтэй тохирч байдаг. Эдгээр схем бүхий үйлдлүүдийг Пиаже лпераци хэмээн нэрлэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Пиажегийн үзэл ёсоор бол, хүүхдийн хөгжлийн дээд үе шатуудад гадаад үйлдлүүд нь интериоризацилагдаж /дотогш шилжиж/, юмсын дүр нь түүний ухамсарт тодорхой шинжийг олсноор логик сэтгэлгээний үндэс болдог. Операциудаар дамжиж хүрээлэн буй орчин

төрөлжиж хуваагдана, орчны элементүүд ойлголт болж хувирна, юм бүрт онцгой төрлийн операциуд оногдож харгалзах болдог. Олон дахин давтагдсан гадаад үйлдлүүд өвөрмөц логик шинжийг объектив байдлаар олдог гэдгийг Пиаже баталжээ. Ийнхүү гадаад үйлдлүүдээс үүссэн логик операциуд нь оюун сэтгэлгээнд цаашдаа өөрийн өвөрмөц зүй тогтол, хуулиудаар хөгждөг болой.

1930-аад оны эхээр алдарт психологич Л.С.Выготский /1896-1934/ хүний хэл /хэл яриа/ хэмээх өвөрмөц репрезентантад хандсанаар интериоризацийн онолд шинэ түлхэц өгсөн билээ. Хэрвээ Пиаже гадаад үйл ажиллагааны бүрдлийг, материаллаг юмс, тэдгээртэй ажиллах схемүүдийг онцолсон бол Выготский юмсын төлөөлөгч болох тэмдгүүдийн үүрэг болон тэмдгэн үйл ажиллагаан дээр анхаарал хандуулжээ. Хүний хувьд рефлексийн бүх систем нь тогтоон барьж, бэхжүүлж бататгаж, хадгалж байдаг нэгэн зүйл байх ба тэр нь үгэн тэмдэг юм гэж үзсэн Лев Семенович "соёлын тэмдэг" хэмээх нэр томъёог психологид оруулж ирсэн нь философид ч утга холбогдлыг олсон юм. Хүн энэхүү соёлын тэмдгүүдийг /хэлэн томъёоллууд, алгебрийн символууд, урлагийн бүтээлүүд, карт зургууд гэх мэт/ эзэмшсэнээр нийгмийн норм, хэм хэмжээнүүдэд өөрийн үйлдлээ бие даан тохируулж, зохицуулж байдаг. Хөдөлмөрийн багажны орлогч болсон эдгээр тэмдгийг эзэмшинэ гэдэг бол чухамдаа хүн төрөлхтний соёлын хөгжилд нэгдэнэ гэсэн үг ажээ.

Выготскийн үзэж буйгаар, ийм тэмдгийг хэрэглэж сурна гэдэг нь уг тэмдгэнд илэрхийлэгдсэн объектив бодит байдал руу нэвтрэх боломж олгодог тийм операциудыг өөриймшүүлнэ гэсэн үг аж. Өөрөөр хэлбэл, уг тэмдэгт репрезентацилагдсан бодот байдлын тэдгээр гол холбосыг гаргаж авах чадвартай болно гэсэнтэй утга нэгэн бөлгөө. Л.С.Выготскийн онолыг А.Р.Лурия, А.Н.Леонтьев, П.Я.Гальперин нар үргэлжлүүлэн хөгжүүлж алдартай сургууль үүсгэсэн билээ. Оюун ухааныг шатлан төлөвшүүлэх гэх мэт тэдний онол нь дотоод үйлдлийг /сэтгэн бодохуйг/ хөгжүүлбэ гэвэл үйлдлээ эхлээд гадаад байдлаар өг, экстериоризаци хий гэсэн зөвлөмж өгдөг билээ.

Эвальд Ильенковын философи арга зүй, Алексей Леонтьевын психологи үндэслэгээ, И.М.Сеченов, А.И.Мещеряков нарын физиологи сургаалтай нэгдэж буй болгосон гайхамшигтай үр дүн нь Москвагийн Загорскийн сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй /хэлгүй-хараагүй-дүлий/ сурагчдад зориулсан сургалтын үйл ажиллагаа болж дэлхийн чихийг дэлдийлгэсэн түүхтэй. Тэдний дундаас хичнээн эрдэмтэн төрсөн гээч!

Резюме

В данной статье автор рассматривает существующие в философской литературе точки зрения по проблеме идеального в обобщённом виде и пытается изложить синтетический подход, охватывающий три основных концепции идеального. При этом он выводит общую логику, сходную с той, которая прослеживается в современной философской дискуссии, обратив внимание на историческое развитие философской мысли.

На этой основе он определяет философский смысл категории идеального и рассматривает операции как его субстрат. И показывает, как

конкретизируется и применяется общая, философская идея в теорию частной, экспериментальной науки, а именно в теорию интериоризации.

Ашигласан ном, бүтээл

1. Дубровский Д.И. Проблема идеального. Субъективная реальность. М., 2002
1. Дубровский Д.И. Психические явления и мозг. М., 1971.
2. Ильенков Э.В. Диалектическая логика. М., 1984.
3. Бэкхерст Д. Философия деятельности. – Вопросы философии, 1996, №5
4. Лифшиц М.А. Об идеальном и реальном. –Вопр. Философии, 1984. №10
5. Антология мировой философии. М., 1969.Т.1,ч.1.
6. Леонтьев А.Н. Проблема деятельности в психологии. – Вопр.Философии, 1972, №9
7. Пивоваров Д.В. Идеальный образ как информационный процесс. – Вкн: Категория образа в гносеологии: структура и функции. Свердловск., 1986
8. Леонтьев А.Н. Культура, поведение и мозг человека. – Вопр.Философии. 1968, №7